

# Элч Паул

-Saint Paul-



120Page

**Тайлбарлагч** Саул маш ухаантай хүн байв. Гэхдээ тэр Есүст итгэдэггүй байлаа.

Бүр Есүст итгэдэг хүмүүсийг үзэн ядаж барьж шоронд хийдэг байв. Саул ахлах тахилчид очин хэлэв.

**Саул** Есүст итгэдэг хүнтэй уулзалал хэн ч бай заавал Иерусалим уруу барьж ир гэсэн захиаг бичиж өгөөч.

**Тайлбарлагч** Саул ингэж Есүсийн дагалдагчдийг барихаар Дамаск руу явлаа.



121Page

**Тайлбарлагч** Саул Дамаскд дөхөн иртэл гэнэт тэнгэрээс нүд гялбам хурц гэрэл тусав. Саулын нүд гялбаж харж чадахгүй байв. Саул гараараа нүүрээ халхалсан ч гэрэл маш хурц байсанд юу ч харж чадахгүй байлаа. Тэр үед тэнгэрээс нэгэн дуу сонсогдов.

**Есүс** Саулаа, Саулаа, чи юунд намайг хавчина вэ?

**Саул** Та хэн бэ?

**Есүс** Би бол чиний хавчиж байгаа Есүс байна

**Тайлбарлагч** Саул Есүс бол амлалтын хаан, загалмайд цовдлогдож нас бараад дахин амьдарсан гэдэгт хүртэл итгэдэггүй байв. Тэгээд Есүсийн дуу хоолойг сонсоод ихэд гайхав.

**Есүс** Саул аа хурдан босоод Дамаск руу яв. Чамд юу хийхийг чинь зааж өгөх хүн байгаа.

**Тайлбарлагч** Юм харж чадахаа больсон Саул хамт явсан хүмүүстэйгээ Дамаск руу очив.



122Page

**Тайлбарлагч** Саул Дамаскд очоод гурав хоногийн турш юу ч харж чадахгүй бас юу ч уухгүй, юу ч идсэнгүй. Саул буруу зүйлээ хийснээ ойлгож Есүст хандан чин сэтгэлээсээ залбирав.

**Тайлбарлагч** Тэр үед Дамаскд Ананиа хэмээх Есүсийн дагалдагч амьдарч байв. Есүс Ананиагийн зүүдэнд үзэгдэж дуудав.

**Есүс** Ананиа, Иудагийн гэр рүү яв. Тэр газар Саул гэгч залуу залбирч байгаа. Чи түүнийг адислан залбирч түүнийг эдгээ.



123Page

**Ананиа** Эзэн минь, би Саулын тухай сонссон. Саул Иерусалимд байгаа итгэгч хүмүүсийг их зовоодог. Энд байгаа итгэгч хүмүүсийг зовоохоор ахлах тахилчаас зөвшөөрөл аваад ирсэн юм

**Есүс** Тэгээд Ананиа Саулыг хайн очиж толгой дээр нь гараа тавин залбирав.



124Page



125Page

**Тайлбарлагч** Явагтун. Тэр намайг мэдэхгүй хүмүүс болон хаад, Израилийн ард түмэнд миний тухай дамжуулуулахаар дуудагдсан нэгэн. Тэр миний нэрийн төлөө зовох учиртайг Би түүнд үзүүлнэ гэжээ.

**Ананиа** Чамтай замд уулзсан Есүс намайг энэ газар руу илгээн, чамайг хараа оруулж итгэлийн хүн болгохын тулд юм.

**Тайлбарлагч** Ананиагийн залбирал дуусмагч, Саулын нүднээс хайрс шиг зүйл унаж Саул дахин хараа оров. Тэгээд Саул босон Ананиагаас уан баталгаа хүртэв. Ингээд Саул Есүсийн дагалдагч болжээ.

**Тайлбарлагч** Саул хоол унд идэж тэнхрэн Дамаскд буй дагалдагч нар болон Есүст итгэдэг хүмүүстэй хэд хоног хамт байв. Тэгээд өөртэй нь уулзсан Есүс Бурханы хүү болохыг дамжуулав.

**Саул** Есүс бол Бурханы хүү. Есүст итгээрэй

**Эрэгтэй** Юу вэ? Есүст итгэдэг хүмүүсийг барьж хавчдаг байсан Саул байна шүү дээ

**Эмэгтэй** Хөөх... Юу болоод байна ?

**Тайлбарлагч** Бүх хүмүүс гайхширсан. Харин Саул улам хүчийг олж, Есүс бол Христ мөн гэдгийг тунхагласан.

**Тайлбарлагч** Олон хоног өнгөрсний дараа, Иудейчүүд Саулыг барьж алахын тулд дааман хаалгануудын дэргэд өдөр шөнөгүй отон хүлээж байв. Гэвч Саул тэдний төлөвлөгөөг мэдсэн байлаа. Тэгээд дагалдагч нар түүнийг сагсанд хийн цайзын гадна гаргаж зугтаалгав. Энэ Саул бол алдартай сайн мэдээ тараагч Паул юм. Паул хэцүү зовлонтой олон зүйлтэй тулгарсан ч тэр олон орноор явж Есүсийн тухай ярьсаар байв. Шинэ гэрээний 13 номыг Паул бичсэн юм.



126Page



127Page